

БАРИЛДААНЫ ХУГАЦАА

	1-3 даваа	4-с дээш
Үндсэн хугацаа	8 минут	12 минут
Сэнжиг, элэг бүс	2 минут	2 минут
Дан золгох (нэг талаар 2 минут)	4 минут	4 минут
Давхар золгох (нэг талаар 2 минут)	4 минут	4 минут
НИЙТ ХУГАЦАА	18 МИНУТ	22 МИНУТ

ДАВААГ ТОДОРХОЙЛОХ

- Барилдааны нийт хугацаа дуусахаас өмнө өрсөлдөгчөө хаясан
ТОХИОЛДОЛД
 - Энэхүү дүрмийн 24.1-д зааснаар өрсөлдөгч бөхөө барилдааны талбайгаас гаргахад оноо тооцох хэдий ч хэрэв талбайн дотроос эхэлсэн мэхний үйлчлэл үргэлжлэн өрсөлдөгч бөхийг унагавал талбайн дотор, гаднаас үл хамааран давсанд тооцно. Өөрөөр хэлбэл талбайн дотроос эхэлсэн мэхний үйлчлэлийг талбай үл хамааран дуустал үргэлжлүүлэн тооцно.
- Барилдааны нийт хугацаа дуусахаас өмнө тухайн бөхийн авсан оноо өрсөлдөгчийн онооноос 10 ба түүнээс дээш болсон тохиолдолд (10:0, 11:1, 12:2 г.м.)
- Барилдааны хугацаа дууссан тохиолдолд их оноотой бөхийг давсанд тооцно.
- Барилдааны хугацаа дуусахад хоёр бөхийн оноо тэнцүү бол сүүлийн оноо авсан бөхийг давсанд тооцно.

ОНОО АВАХ

- Өрсөлдөгч бөхийг шахаж барилдан барилдааны талбайн захын гадна бүтэн улаар гишгүүлэх. Барилдааны явцад бөхчүүдийн барилдаан хивс дэвсгэрийн, эсвэл барилдааны тогтоосон талбайн гадна гишгэсэн ч мэх, хүчний үйлчлэлээр барилдаан үргэлжилж байвал барилдааныг шууд зогсоохгүй үргэлжлүүлэх ба харин хашлага, рекламны самбарт тулах, барилдаан удааширч хэвийн байдалд шилжих зэрэг тохиолдолд талбайн цэц барилдааныг зогсоож төв байршлаас эхлүүлнэ.
- Хийсэн мэхний үйлчлэлээр өрсөлдөгч бөхийн гар талбайн гадаргуу (газарт)-д хүрвэл
- Хайна болсон тохиолдолд мэх хийсэн бөхөд нэг оноог өгөх

ОНОО АЛДАХ

ЭХНИЙ УДАА САНУУЛААД, САНУУЛГЫГ БИЕЛҮҮЛЭХГҮЙ БОЛ ӨРСӨЛДӨГЧ БӨХӨД ОНОО ӨГНӨ.
ДАРААГИЙН УДАА САНУУЛГАГҮЙГЭЭР ШУУД ОНОО ӨГНӨ

- Илэрхий зугтсан
- Барилдахаас зайлсхийж цаг авсан
- Барьц өгөхгүй байх зорилгоор буруу халсан
- Барилдааныг хэвийн үргэлжлүүлэх боломжийг 30 секундээс илүү хугацаагаар саатуулсан, үүнд дан ба давхар золгох үед барьц өгөхөөс цааргалах, саатуулах, барьцыг дутуу өгч халах зэрэг багтана.
- Цэц, шүүгчийн шаардлагыг биелүүлэхээс татгалзах болон биелүүлэхгүй удаашрах
- Барилдааны явцад спортын бус ёс зүйгүй үйлдэл гаргасан
- Даваа бүрийн эхлэлд барилдааны талбайд бөхчүүдийг дуудснаас хойш буюу албан ёсны хуваариас хойш 2 минутын дотор талбайд гарч ирээгүй бөх хүндэтгэн үзэх шалтгаангүй бол өрсөлдөгч бөхөд нэг оноо өгнө. Үргэлжлүүлэн гарч ирэхгүй бол дараагийн 30 сек тутамд өрсөлдөгч бөхөд нэг оноо өгнө.
- Барилдааны явцад бөхчүүд зайлшгүй шалтгаанаар барилдааныг түр завсарлуулах бол шүүгчээс заавал зөвшөөрөл авна. Зөвшөөрөлгүй үйлдэл бүрт сануулга, улмаар өрсөлдөгч бөхөд оноо нэмж өгнө.